*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ ГАНБАТЫН БАТБОЛДЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

<table>
<tr><th rowspan="2">Д/д</th><th rowspan="2">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th rowspan="2">Шалгуур үзүүлэлт</th><th colspan="5">Гүйцэтгэлийн түвшин</th></tr>
<tr><th>Суурь түвшин</th><th>Хүрэх түвшин</th><th>Хүрсэн түвшин (биелэлт)</th><th>Эхэлсэн, дууссан хугацаа</th><th>Биелэлтийн хувь</th></tr>
<tr><td></td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 1.“Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт”</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 1. “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</td></tr>
<tr><td>1.1.</td><td>(ЗХХГТ-1.1) Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга) болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;</td><td>Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо</td><td>Хууль-4<br>Дүрэм, журам, заавар-101</td><td>100%</td><td>Нийгмийн даатгалын багц хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлтэй тухай бүрт танилцан хэрэгжүүлж, ажлын байран дээр мөрдлөг болгон ажилласан. НДЕГ-аас шинээр нэвтрүүлсэн SICOS программтай холбоотой гарсан тушаал, аргачлал, чиглэлүүдийг дагаж мөрдөн, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</td><td>2025.01.02<br>2025.06.30</td><td></td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 2. “Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт”</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 2.1:** “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1 1. | (ЗХХГТ-2.1.1.)<br><br>1.Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу газрын сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалтыг хийх; | Тухай бүр | Дотоодын хяналт шалгалтын хүрээнд тэтгэмжийн даатгалын сангаас олгосон Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тоо-1780<br><br>НБДГБГишүүнд олгох тэтгэмжийн тоо 346 ҮОМШӨДСангаас ХЧТАТэтгэмжийн тоо 79<br><br>Тэтгэвэр авагч тоо 7192 шалгаж Жирэмсний болон амаржсаны тэтгэмж 17 даатгуулагчид 40.3 сая төгрөгийн акт тавьж тэтгэмжийг хуулийн хугацаанд нь шалгаж гарсан зөрчлийг тухай бүрд нь арилгаж ажилласан. | - | 1. Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын баталсан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 06 тоот удирдамжийн дагуу ажилгүйдлийн даатгалын сангийн зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, 2023 онд ажилгүйдлийн тэтгэмж авсан 560 даатгуулагчийн тэтгэмж, 2024 онд ажилгүйдлын даатгалын сангаас ажилгүйдлын тэтгэмж авсан 720 даатгуулагийн тогтоолт, бодолт, олголтыг мэдээллийн нэгдсэн баазтай тулган шалгалаа. шалгаж 51 даатгуулагчийн мэдээллийг нягтлан ажилласан.<br><br>2 Мөн 2024 оны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, цэргийн алба хаасан, ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгож байгаа зэрэг тэтгэврийн бодолт, олголт, хувийн хэрэг тулган тоолох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| | (ЗХХГТ-2.1.1.)<br><br>2.Дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг 70%-аас доошгүй барагдуулах; | Хэрэгжилтийн хувиар | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж 17 даатгуулагчид 40.3 сая төгрөгийн акт тавьж 12.1 сая төгрөгийн тэтгэмжийг | - | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж 17 даатгуулагчид 40.3 сая төгрөгийн акт тавьж 12.1 сая төгрөгийн барагдуулсан. Тэтгэмжийн олголтод хийсэн дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг оны | 2025.01.02<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуулийн хугацаанд барагдуулсан. | | сүүлийн хагас жилд 70 доошгүй хувиар бууруулахаар ажиллаж байна. | | |
| | (ЗХХГТ-2.1.1)<br><br>3. 2024 онд ирүүлсэн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хяналт шалгалт хийх; | Хэрэгжилтийн хувиар | Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хяналт, шалгалт хийх 04 тоот удирдамжийн дагуу 2 байцаагчийн 1099 ажил олгогчийн 26995 даатгуулагчийн шимтгэлийн тайланг нийгмийн даатгалын ерөнхий хууль, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан тогтоол, шийдвэр, журмын хүрээнд шалгалаа. | - | 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 05 тоот ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хяналт, шалгалт хийх ажлын удирдамжийг батлуулсны дагуу 2024 онд тус газарт бүртгэлтэй идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэл төлөлтийн тайлан, холбогдох баримтуудыг гаргуулахаар ажиллаж байна. Хяналт, шалгалтын ажлыг ГТ-нд тусгагдсаны дагуу сүүлийн хагас жилд гүйцэтгэн, үр дүнг тооцон ажиллана. | 2025.07.01<br>2025.12.31 | |
| | (ЗХХГТ-2.1.2)<br><br>1.Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг дээд газраас ирүүлсэн удирдамж чиглэл болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх; | Тухай бүр | Газрын даргын 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 03 тоот, Мөн газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 06 тоот Тээврийн үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 100.0 саяас дээш нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 27 байгууллагын 3,111,316.5 мянган төгрөгийн шимтгэлийн авлага барагдуулж 49 аж ахуйн нэгжтэй холбоотой 606.723.3 мянган төгрөгийн цалингийн санд 136.121.4 | 100% | 2025 оны эхний хагас жилийн хугацаанд Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хяналт, шалгалт хийх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Тодруулбал 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 02 тоот Их, дээд болон коллеж, ерөнхий боловсролын сургуулийн байгууллагуудад нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах удирдамжийн дагуу 6 ажил олгогчийн 78 даатгуулагчийн 66,220.9 мянган төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлэн эдгээр зөрчлийг ажил олгогчоор бүрэн төлж барагдуулсан. | 2025.01.02<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | | | мянган төгрөгийн акт, 66.082.2 мянган төгрөгийн алданги тооцож нийт 202.203.6 мянган төгрөгийн зөрчлийг 99 хувь барагдуулсан. | | | | |
| | (ЗХХГТ-2.1.2)<br><br>2. Аж ахуйн нэгж байгууллагуудад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг 70%-аас доошгүй барагдуулж ажиллах; | Хэрэгжилтийн хувиар | 81% | 100% | 2025 оны эхний хагас жилийн хугацаанд Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хяналт, шалгалт хийх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Тодруулбал ирүүлсэн удирдамж, чиглэл, өргөдөл, гомдолын дагуу хийгдсэн хяналт, шалгалтаар нийт 40 ажил олгогч байгуулллага, 129 даатгуулагчтай холбоотой хууль зөрчсөн 64,900,9 мянган төгрөгийн төлбөрийг зөрчил илэрч, эдгээр зөрчлийг ажил олгогчоор бүрэн барагдуулсан. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| | ЗХХГТ-2.1.2)<br><br>3. Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлын хүрээнд хяналт, шалгалтыг хийх; | Тухай бүр | 15 аж ахуйн нэгжтэй холбоотой 155,780.9 мянган төгрөгийн цалингийн санд 37,585.3 мянган төгрөгийн акт, 16,936.6 мянган төгрөгийн алданги тооцож нийт 54,521.9 мянган төгрөгийн зөрчлийг 100 хувь барагдуулан ажилласан байна. | 100% | Эхний хагас жилийн байдлаар НДЕГазрын даргын удирдамж, БГДүүргийн НДГазрын даргын удирдамж, ААНБ-аас ирүүлсэн албан бичиг, өргөдлийг шийдвэрлэн 40 ажил олгогчын 129 даатгуулагчийн нийгмийн баталгааг хангаан ажилласан. Зөрчлийг арилгасаны дараа тухайн шимтгэлийн мэдээллийг даатгуулагч тус бүрээр нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн баазад баталгаажуулан бүртгэж, системд оруулах ажлыг бүрэн гүйцэтгэв.<br>Даатгуулагчдын эрх ашгийг хамгаалж, ажил олгогчийн үүрэг | 2025.01.02<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцлагыг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах илэрсэн зөрчил арилгах, урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. | | |
| 2.1.3. | (ЗХХГТ-2.1.3) Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | Хэрэгжилтийн хувиар | - | 40% | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн нэр бүхий их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд 3 байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 7 байгууллагад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, 6 ажил олгогчтой холбоотой 111 даатгуулагчийн 82,802.1 мянган төгрөгийн төлбөр, зөрчлийг илрүүлж, акт, алдангийг бүрэн төлж барагдууллаа. Мөн 1 байгууллагад нийгмийн даатгалын улсын байцаагчийн зөвлөмжийг өгч ажиллалаа. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 2.1.4. | (ЗХХГТ-2.1.4) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | Хэрэгжилтийн хувиар | - | - | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан ажиллана. | 2025.07.01<br>2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5. | (ЗХХГТ-2.1.7) Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | 2 удаа | 2 | 1 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас жилээр гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 2.1.6. | (ЗХХГТ-2.1.8) Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | 2 удаа | 2 | 1 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 2.1.7. | (ЗХХГТ-2.1.10) Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжүүлсэн тоогоор | - | Тухай бүр | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэн, тайлан мэдээг цаг хугацаанд нь гарган, хуулийн хэрэгжилтийн үр дүнг тооцож, 2 ажил олгогчид 2,5 сая төгрөгийн торгууль оногдуулж илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн барагдуулан ажиллаж байна. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай | 2025.01.02<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулийн хэрэгжилтийн талаар харъяа прокурорын газраас сургалт авч ирүүлсэн заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| **Гурав. *Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 3:*** *"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ*** | | | | | | | |
| 3.1. | (ЗХХГТ-3.2) Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | Тухай бүр | 61 | Тухай бүр | Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 39 албан хүсэлт, 11 иргэний өргөдлийг хүлээн авч нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагчийн өргөдөл, хүсэлтэд үндэслэн шалгаж хуулийн хэрэгжилтийг хангуулан, хууль зөрчсөн үйлдэлд акт, алданги тооцож, хохирол, нөхөн төлбөрийг 100 хувь барагдуулан ажилласан байна. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 3.2. | (ЗХХГТ-3.6) Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргах; | Тухай бүр | 100% | 100% | Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. | 2025.01.02<br>2025.02.15 | |
| 3.3. | (ЗХХГТ-3.8) Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хүргүүлж ажиллах; | Тухай бүр | 100% | 100% | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хүргүүлэн ажилласан. | 2025.01.02<br>2025.06.30 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхээр зохион байгуулсан сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдах; | Сургалтын тоогоор | 23 | 6 | 2025 оны хагас жилээр мэргэжил мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан танхимын 5 удаагийн сургалтад хамрагдсан.<br>1.Ажлын байран дахь стресс, түүнийг даван туулах арга зам,<br>2.Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага,<br>3.Нурууны суулт түүнээс урьдчилан сэргийлэх,<br>4.Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх,<br>5.НДЕГ-ын зохион байгуулсан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, хэрэг бүртгэлтийн мэдээллийг бүртгэх, хянах цахим системийн тухай сургалт,<br>6.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам сэдвүүдээр тус тус танхимын сургалт сурч мэдлэг ур чадвараа дээшлүүлэн ажиллалаа. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 2. | “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулахад бэлтгэгдсэн байх тул монгол бичгээр уншиж, бичиж сурах | Сургалтын тоогоор | - | 1 | Монгол бичгийн цахим сургалтад бүрэн хамрагдаж мэдлэгийн түвшинг нэмэгдүүлсэн. | 2025.01.02<br>2025.06.30 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ: ................................/Г.БАТБОЛД/ ......... ......... .........
*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргах, Биелэлтээ тайлагнах | Төлөвлөгөө-1<br>Тайлан-2 | 92.2% | 93% | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хагас жилээр төлөвлөгөөний гүйцэтгэлийг тайлагнаж, тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 2. | Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн талаарх сургалтыг ААНБ, олон нийтийн байгууллагад хийх, зохион байгуулах | Тухай бүр | 7 | 5 | 2025 оны хагас жилээр дараах сургалтыг ААНБ болон ОН-ийн байгууллагад зохион байгуулсан. Үүнд:<br>1. Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан дүүргийн 34 хорооны Засаг дарга, ажлы алба, хорооны нийгмийн ажилтан нарт нийгмийн даатгалын багц хуулиар<br>2. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын ХҮТ-9 хамт олонд нийгмийн даатгалын багц хуулиар<br>3. Дүүргийн Засаг даргын тамгын газрын хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд Нийгмийн даатгалын багц хуулийн талаарх сургалтыг<br>4. Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг сурталчилах, хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалт, өдөрлөгийг Мандах их сургууль дээр тус тус зохион байгууллаа.<br>5. УБТЗ-ын Зоричигчийн вагон депогийн удирдах болон ажил удирдагч 60 ажилтанд нийгмийн даатгалын багу хуулийг таниулах сургалтыг зохион байгуулсан. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 3. | Тайлан мэдээ, хяналт шалгалтын баримтууд | Баримтын тоогоор | 19 | 19 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 2024 оны жилийн эцсийн хяналт, | 2025.01.02<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон холбогдох бусад баримт бичгийг архивын нэгж болгон зохих журмын дагуу хүлээлгэж өгөх | | | | шалгалтын тайлан мэдээ, хяналт, шалгалт хийх удирдамж, улсын байцаагчийн акт, зөвлөмж, зөчлийн хэргийн баримт материалыг архивын стандартын дагуу үдэж цэгцлэн архивт хүлээлгэн өгсөн. | | |
| 4. | Угтах үйлчилгээний ажилтнаар хуваарийн дагуу ажиллах | Тухай бүр | - | - | Газрын даргын баталсан тушаалаар угтах үйлчилгээний ажилтнаар ажиллана. | 2025.01.01<br>2025.12.31 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ: ................................ / Г.БАТБОЛД / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргах, Биелэлтээ тайлагнах | Төлөвлөгөө-1<br>Тайлан-2 | 92.2% | 93% | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хагас жилээр төлөвлөгөөний гүйцэтгэлийг тайлагнаж, тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 2. | Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн талаарх сургалтыг ААНБ, олон нийтийн байгууллагад хийх, зохион байгуулах | Тухай бүр | 7 | 5 | 2025 оны хагас жилээр дараах сургалтыг ААНБ болон ОН-ийн байгууллагад зохион байгуулсан. Үүнд:<br>1. Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан дүүргийн 34 хорооны Засаг дарга, ажлы алба, хорооны нийгмийн ажилтан нарт нийгмийн даатгалын багц хуулиар<br>2. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын ХҮТ-9 хамт олонд нийгмийн даатгалын багц хуулиар<br>3. Дүүргийн Засаг даргын тамгын газрын хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд Нийгмийн даатгалын багц хуулийн талаарх сургалтыг<br>4. Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг сурталчилах, хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалт, өдөрлөгийг Мандах их сургууль дээр тус тус зохион байгууллаа.<br>5. УБТЗ-ын Зоричигчийн вагон депогийн удирдах болон ажил удирдагч 60 ажилтанд нийгмийн даатгалын багу хуулийг таниулах сургалтыг зохион байгуулсан. | 2025.01.02<br>2025.06.30 | |
| 3. | Тайлан мэдээ, хяналт шалгалтын баримтууд болон холбогдох бусад баримт бичгийг архивын нэгж болгон зохих | Баримтын тоогоор | 19 | 19 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 2024 оны жилийн эцсийн хяналт, шалгалтын тайлан мэдээ, хяналт, шалгалт хийх удирдамж, улсын байцаагчийн акт, зөвлөмж, зөчлийн хэргийн баримт | 2025.01.02<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журмын дагуу хүлээлгэж өгөх | | | | материалыг архивын стандартын дагуу үдэж цэгцлэн архивт хүлээлгэн өгсөн. | | |
| 4. | Угтах үйлчилгээний ажилтнаар хуваарийн дагуу ажиллах | Тухай бүр | - | - | Газрын даргын баталсан тушаалаар угтах үйлчилгээний ажилтнаар ажиллана. | 2025.01.01<br>2025.12.31 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ: .............................. / Г.БАТБОЛД / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*